

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 10-ны өдөр

№ 15

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь “Мони маркет фонд” ХХК-тай 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг хүртэлх эх үүсвэр авах, өгөхтэй холбоотой хэлцэл буюу сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан эсэх талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлд улирал бүр тайлагнаж байхыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын 3-д заасан тайланг үндэслэн Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийн хугацааг сунгах эсэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэхийг дурдсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 10-ны өдөр

№ 16

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь нэгдмэл сонирхолтой нэр бүхий компаниудтай сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралтад заасан нөхцөлөөр байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ





Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх НӨХЦӨЛ

№	Компанийн нэр	Хэлцлийн нэр	Хэлцлийн нөхцөл	Хэлцлийн үнийн дүн
1	Хай пэймэнт солюшнс ХХК	Мерчанттай хамтран ажиллах гэрээ	HiPay-ээс Мерчантын бараа, ажил үйлчилгээний төлбөрийг “HiPay цахим мөнгө” болон Монгол улс дахь арилжааны банкуудын бүх төрлийн карт, “HiPay-QRC” төхөөрөмж, “QR код”-оор дамжуулан хүлээн авах, хүлээн авсан төлбөр тооцоог мерчантад шилжүүлэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх аливаа харилцааг зохицуулна.	-
		Хамтран ажиллах гэрээ	HiPay-д “Alipay remittance” системээр мөнгөн гуйвуулга илгээх эрхийг олгож, түүгээр гүйцэтгэсэн мөнгөн гуйвуулгын тооцооны тулгалтыг гүйцэтгэж HiPay-аас нэхэмжлэх, HiPay нь зохих шимтгэлийг Sendly-ээс авах, Талуудын хооронд үүсэх бусад харилцааг зохицуулна.	Гүйлгээний шимтгэлийн төлбөр /тухай бүр/
		Үйлчилгээ үзүүлэх гэрээ	Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүртгэл, санал хураалт, тайлагналыг цахим болгоход шаардлагатай программ хангамж үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцооны харилцааг зохицуулна.	Хай пэймэнт солюшнс ХХК-ийн ирүүлсэн нэхэмжлэлээр төлнө. /хувьцаа эзэмшигчдийн хурал тутамд/
2	Стоклаб секьюритиз УЦК ХХК	Үнэт цаасны зөвлөх үйлчилгээний гэрээ	Компанийн хувьцааны ханшийн өсөлт, уналтанд хяналт тавих, анализ хийх, тайлан гаргах, удирдлагуудад мэдээллэх, зөвлөгөө өгөх	5,850,000 төгрөг /нэг сарын/
3	Мони маркет фанд ХХК	Итгэлцлийн үйлчилгээ зуучлах мастер гэрээ	“Мони маркет фанд” ХХК нь өөрийн хөгжүүлж, нэвтрүүлсэн Хэлцлийн талбараар дамжуулан итгэлцлийн үйлчилгээг “Сэндли ББСБ”-д зуучлахтай холбоотойгоор Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.	Жилийн хураамж 50,000 төгрөг Арилжааны шимтгэл 6 сар - 0,05% 1 жил – 0,1%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 10-ны өдөр

№ 17

Улаанбаатар хот

Комплаенсын мэргэжилтэн томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Батдоржийн Хоролгарав /РД:ИЦ90012202/-ыг “Сэндли ББСБ” ХК-ийн Комплаенсын мэргэжилтнээр 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Хоролгаравтай хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, нууцын гэрээг байгуулах ажлыг зохион байгуулахыг Хүний нөөцийн менежер /Т.Бадмаанямбуу/-д, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж, хөдөлмөрийн зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д тус тус үүрэг болгосугай.

3. Ажилтныг түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу хавсралтад заасан дүнгээр тооцож цалинжуулахыг Ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

